



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР**

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

**Авто зам, гүүрийн барилгын ажлыг
эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийслэлийг аймгийн төвүүдтэй холбох зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

1. Улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжиж буй авто зам, гүүрийн барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх, хэрэгжилтийг хангах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн төв, Төсөл хэрэгжүүлэх нэгжүүд, хөндлөнгийн хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд, гүйцэтгэгч байгууллагуудад дараах арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай.

1.1. Барилга угсралтын ажлыг батлагдсан нарийвчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгүүлэх, ажлын явц удааширсан төлөвлөгөөний биелэлт тасарсан тухай бүрт нь шалтгааныг тогтоож, ажлыг эрчимжүүлэх хоцрогдлыг нөхөх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;

1.2. Авто зам, замын байгууламжийг батлагдсан зураг төсөл, стандарт нормын дагуу чанартай гүйцэтгүүлэхэд онцгой анхаарч гэрээт хугацаанд ашиглалтад оруулах;

1.3. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, газар олгох, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, газар чөлөөлөх зэрэгтэй холбоотой асуудлыг орон нутагтай хамтарч шуурхай шийдвэрлэх;

2. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, алдаа дутагдал гаргасан, чанаргүй ажил гүйцэтгэсэн түүнийг хүлээн авсан зэрэг зөрчил гаргасан албан тушаалтан, аж ахуй нэгж байгууллагатай гэрээний холбогдох заалтууд болон хууль тогтоомжийн хүрээнд хатуу хариуцлага тооцож ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.

САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ